

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЭРХ ЗҮЙН АКТЫН СИСТЕМЧЛЭЛ, ТҮҮНИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛ

POLICE STANDARD OPERATING PROCEDURE, ITS IMPROVEMENT AND DEVELOPMENT



Д.ЭРДЭНЭБААТАР

ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн
хүрээлэнгийн захирал, дэд комиссар

ERDENEBAATAR D.

Director of Research and Development Institute,
Law Enforcement University, Deputy Commissioner

Товч утга: Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, Монгол Улсын хуулиуд, нийтээр дагаж мөрдөх журам агуулсан хэм хэмжээний актууд болон тэдгээрт нийцүүлэн цагдаагийн төв байгууллагаас гаргасан үйл ажиллагааны журмууд цагдаагийн байгууллагын эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлдэг.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг төгөлдөршүүлэх нь байгууллага, алба хаагчийн хүсэл зоригийн төдийгүй төрийн бодлогын хэмжээнд тавигдаж буй асуудал бөгөөд түүнийг батлагаажуулсан хэм хэмжээний актууд, бодлогын баримт бичгүүд гарсаар байна. Тухайлбал, Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг дурьдаж болно.

Энэхүү илтгэлийн зорилго нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг кодчилж системчилэх, түүний агуулга, ач холбогдол, гадаад орны туршлагыг гарган тавих, улмаар хууль сахиулах, төрийн байгууллагад нэвтрүүлэх саналыг дэвшүүлэн гаргахад чиглэгдэнэ.

Abstract: Under the international contracts, Mongolian Constitution, laws, and regulations, police standard operation procedures is issued by National Police Agency to make up the legal framework for the police.

As a result of both government and police officials always want to develop police legal regulations, some police documents and regulations have been made in recent years. For instance, based on the Mongolian Millennium Development intention, National Development Strategy was emerged so far. Moreover, Police Development Program and Strategic objectives of the Action Plan can be mentioned.

This paper (speech or report) is dedicated how to improve police regulations such as Standard Operation Procedures and its code, content, importance, requirements, and adopting foreign practice because comprehensive SOPs have many important functions in law enforcement and state agencies.

Стандарт журмын эх сурвалж

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн баримт бичгүүдийн системчлэлийн талаар АНУ, Канад, Англи, Япон, Сингапур улсын туршлагыг судлахад байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн баримт бичгийн үүсэл хөгжил нь "Bylaw" буюу хот, тосгоны хууль гэдгээс гаралтай байна.¹

Bylaw гэдэг нь төрөөс батлан гаргасан хууль тогтоомжид нийцүүлэн орон нутгийн засаг захиргаа, хуулийн этгээд, байгууллагаас батлан гаргасан зөвхөн тухайн нутаг дэвсгэр, байгууллагын хүрээнд хэрэгжих шинжтэй эрх зүйн актыг хэлдэг.

Орон нутгийн засаг захиргаа, байгууллагаас тогтоосон эрх зүйн актын хэлбэр, бүтэц, зохицуулалт нь илүү байнгын шинжийг агуулдаг бөгөөд ихэнхидээ "код, дүрэм, журам" зэрэг нэрээр нэршсэн байна.

By law гэдэг үгний гарал үүсэл нь тодорхой биш боловч хамгийн боломжтой хувилбар нь 14 болон 18 дугаар зууны үед одоогийн Англи улсын нутаг дэвсгэр дээр тухайн үедээ хамгийн том суурьшмал иргэншлийг үүсгэсэн, эртний Герман хэлний "Whit by" болон Derby нэртэй хотуудын "by", 9-11 дүгээр зууны үеийн Английн Viking хотын засаг захиргаанаас тогтоосон хууль болох "Dane law"-гэдэг үгний "Law" гэсэн үгний нийлбэр гэж үздэг.² Европын зарим улс буюу Дани, Швед, Норвег зэрэг улсуудад хот, тосгоныг "by" гэж одоог хүртэл нэрлэдэг.

By law буюу хэм хэмжээний акт нь 3 үндсэн төрөлтэй байна. Үүнд:

1. Орон нутгийн засаг захиргаанаас тогтоосон акт (Municipal bylaws);
2. Байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалтын акт (Corporate and organizational by laws)³;
3. Төрийн бус байгууллагын дүрэм, журам (Union bylaws).

Тэгвэл байгууллагын стандарт журам нь зөвхөн тухайн байгууллагын дотоодод үйлчлэх, үйл ажиллагаагаа үр дүнтэй зохион байгуулахад шаардлагатай загвар, аргачлал, дэг горимыг тогтоосон эрх зүйн баримт бичиг юм.

Энэ нь байгууллагын хувьд бүхий л стандарт журам болон үндсэн зарчмыг багтаан үйл ажиллагаагаа цэгцтэй, үр дүнтэй явуулах, дотоодын эрх зүйн актуудын хоорондын зөрчлийг арилгах, хэрэглэхэд хялбар болгох зорилготой бөгөөд төрөөс тогтоосон бусад хууль тогтоомж, практик дахь хэрэгжилт, гарч байгаа зөрчил болон ажил мэргэжлийн туршлагад тулгуурласан байдаг.

Байгууллагын стандарт журам нь байгууллага бүрт өөр байх боловч ерөнхийдөө удирдах ажилтныг хэрхэн сонгож томилох, тэдний үүргийг тодорхойлох, ажилтан болон байгууллагын үүргийг тодорхойлох зэрэг үндсэн асуудлыг тусгасан байдаг. Ер нь ямар ч стандарт журам нь нэр, зорилго, ажилтан, удирдлагын эрх, үүрэг, журам боловсруулах хороо, нэмэлт, өөрчлөлт оруулах журам зэргийг багтаасан байдаг.

Ийнхүү аливаа байгууллагын үйл ажиллагааны бодлогыг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай ажиллагааг зохицуулсан журмыг тогтоосон цогц эрх зүйн баримт бичгийг **Policy and procedure** гэх болсон байна.

¹ Эрх зүйн дэд акт гэж орчуулж болох бөгөөд англи хэлээр **By-law, by law, bye-law** гэх зэргээр бичдэг.

² Oxford English Dictionary

³ [Doreen Martel](http://www.brighthub.com/office/entrepreneurs/articles/43973.aspx) What are Corporate Bylaws? 2011 <http://www.brighthub.com/office/entrepreneurs/articles/43973.aspx>

Байгууллагаас тогтоодог стандарт журам буюу бодлого, үйл ажиллагаагаа зохицуулсан журмыг **"Business policies and procedures", "Standard operating procedures (SOP)", "Department operating procedures (DOP)"** гэх зэргээр маш олон янзаар нэрлэдэг бөгөөд энэ илтгэлд "Стандарт журам" гэж томъёоллоо.⁴ Манай улсын хууль тогтоомжид хөдөлмөрийн дотоод журам гэж томъёолсон байдаг.

Байгууллагын удирдлага дангаараа журмаа өөрчлөдөггүй, ихэнх байгууллагуудад нийт ажилтнуудын дийлэнхи олонхийн буюу 2/3-ны саналаар нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэдэг. Энэ нь ажилтнуудын олонхийн хүсэлт зоригт нийцсэн, тэдний зөвшөөрлөөр нэгтгэгдэн батлагддаг учраас тухайн байгууллагыг удирдах, үйл ажиллагаандаа баримтлах хамгийн гол баримт бичиг болдог.

Стандарт журмын загвар⁵

Стандарт журмыг боловсруулахдаа өөрчлөлтүүдийн бүрэн түүхийг багтаасан тогтсон стандарт формат загварыг ашиглаж хэвшсэн байна. Үүнд нэр, зорилго, хамрах хүрээ, баталсан өдөр, хүчин төгөлдөр болох өдөр, шинэчилсэн, нэмэлт, өөрчлөлт оруулсан огноо, зарим тохиолдолд үндэслэл, бодлогоо тайлбарласан хэсэг, нэр томъёоны тодорхойлолт, үүрэг хариуцлага, үйл ажиллагааны дэг горим багтана. Жишээ нь:

ЖУРМЫН НЭР	Код	
	Хүчин төгөлдөр болсон өдөр	
	Шинэчилсэн/нэмэлт өөрчлөлт оруулсан өдөр:	
	Шинэчилсэн/нэмэлт өөрчлөлт оруулсан шийдвэрийн дугаар	
	Хуудасны тоо	
	Батлагдсан	
Зорилго – журмын зорилгын тайлбар Шинэчлэсэн түүх – нэмэлт, өөрчлөлтийн жагсаалт Хамрах хүрээ – хэрэглэх, хэрэгжүүлэх ажилтан Бодлого – байгууллага зорилгодоо хүрэх арга зам зарчмыг тодорхойлох Нэр томъёоны тодорхойлолт – товчилсон үг, нэр томъёоны тайлбар Үүрэг хариуцлага – журмыг хэрэгжүүлэх ажилтны хүлээх үүрэг, хариуцлага Дэг горим – удирдлага, аргачлал, цаг хугацаа, газар, бодлогыг хэрэгжүүлэх тодорхой этгээдийн хариуцах ажил зэрэг		

Стандарт журмыг гаргах шаардлага

Байгууллагын стандарт журмыг гаргах шаардлагын маш урт жагсаалт гаргаж болох боловч үндсэн 5 шаардлагыг авч үздэг байна.

1. Зохион байгуулалтын шаардлага – байгууллагын үндсэн хэрэгцээг жигд хангахуйц зохион байгуулалтын ажлын арга замыг тодорхойлж баталгаажуулах;
2. Эрсдлийн удирдлага – боловсруулсан журам нь эрдслийг удирдахад шаардлагатай хяналтын үйл ажиллагааны дэг горимыг тогтоох;
3. Тогтмол үр дүн - журам нь байгууллагын дотоод үйл ажиллагааны практикт тулгуурлан процессыг цаг үргэлж сайжруулдаг;
4. Зөрчилдөөнийг тогтоох – сайтар боловсруулсан ба албажуулсан процесс

⁴ David Grusenmeyer, Developing Effective Standard Operating Procedures
Sr. Extension Associate PRO-DAIRY, Cornell University

⁵ Quebec Police Agency Development, Approval and Review of Standard Operating Procedures (SOPs)

(журам, сургалт)-ийг хэрэгжүүлэх нь удирдлагын тогтолцоо болон стандарт журмын хэм хэмжээний хоорондын зөрчлийг олж илрүүлэх үр дүнтэй арга.

АНУ-ын Харвардын их сургуулийн профессор Л.Л.Фуллер аливаа улсын эрх зүйн тогтолцоог гажуудалд хүргэдэг 8 шалтгааныг тогтоосон бөгөөд энэхүү зарчмын аль нэг нь бий болбол төр улс, эрх зүйн тогтолцоо үгүй болдог гэжээ.⁶

Үүнийг байгууллагын төвшинд авч үзвэл байгууллагын стандарт журмыг тогтоох талаарх бодлогын алдаа, байгууллага болон түүний гаргасан стандарт журмын талаар олон нийт, ажилтнууд ойлголтгүй байх, стандарт журмын ойлгомжгүй байдал, түүнд шинэчлэл хийхээс татгалзах, журмын зүйл заалтуудын зөрчил, удирдлага ба ажилтнуудын эрх үүргийн хувиарлалтын алдаа, зохих эрх хэмжээг олгохгүй байх, хууль тогтоомжийн тогтворгүй байдал, удирдлагын бодлого, шийдвэр, үйлдэл нь тогтоосон журамтай зөрчилдөх гэсэн асуудлыг авч үзэж болно.

Цагдаагийн байгууллагын стандарт журам

Дээр дурдсан орнуудын цагдаагийн байгууллагын хувьд байгууллагын үйл ажиллагааг удирдах, хянах, алба хаагчийн үүргээ гүйцэтгэх явцад урьдаас урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдал үүссэн үед тухайн нөхцөл байдлыг хяналтдаа авах, шийдвэр гаргах зааварчлагаар хангахын тулд стандарт журмыг гаргадаг байна. Ингэхдээ удирдлагаас алба хаагч бүр тодорхой нөхцөл байдалд зайлшгүй хийж гүйцэтгэх болон хийж болохгүй үйлдэл, тохиромжтой шийдвэр гаргах чадвартай болгох асуудалд онцгой анхаардаг байна. Жишээлбэл, өөрийн болон бусдын эрүүл мэнд, амь насыг хамгаалах зорилгоор хүч хэрэглэх стандарт (галт зэвсгийг сануулж эсхүл, сануулахгүй хэрэглэх, явж байгаа тээврийн хэрэгсэл рүү ямар тохиолдолд буудах гэх зэргээр)-ыг тогтоодог.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам буюу стандарт нь орчин үеийн цагдаагийн байгууллагын удирдлагын гол арга хэрэгсэл гэж профессор С.Волкерийн “Америкийн цагдаагийн байгууллага” номд бичжээ. Энэ номонд бичснээр стандарт журамд 2 үндсэн дутагдал байдаг. Нэгдүгээрт, дүрэмт хувцас хэрэглэх гэх мэт зарим асуудалд ач холбогдол өгдөггүй, шинэчлэлийг хүлээж авдаггүй уламжлал тогтсон байдаг. Хоёрдугаарт, шинээр бий болсон тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд саад болдог байна.

Их Британийн цагдаагийн алба хаагч П.Мэнин “бид цагдаагийн стандарт журмыг 140 жилийн турш хийж, сайжруулж ирлээ, гэтэл цаг үргэлж ямар нэг алдаа гарч байна...” гэж хэлсэн байдаг. Эндээс үзэхэд цагдаагийн байгууллагын стандарт журам нь их урт түүхтэй, олон арван жилийн туршид хөгжүүлж, боловсронгуй болгож иржээ.

1829 оны үед Англи улсын Лондон хотын цагдаагийн газар байгуулагдсныг орчин үеийн цагдаагийн үүсэл гэж үздэг. Англи улсын хувьд цагдаагийн байгууллага нь байгуулагдснаасаа хойш хагас зуун жилийн дараагаас стандарт журмаа гаргаж байжээ.

Дээр дурдсан орнуудын цагдаагийн байгууллагын туршлагаас үзэхэд дэргэдээ Судалгааны алба байгуулах, судалгаа, шинжилгээний үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран ажиллах зэргээр Стандарт журмаа системчилж, сайжруулах ажлыг зохион байгуулдаг байна.

Японы Үндэсний Цагдаагийн газарт Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны

⁶ Lon Luvois Fuller The Morality of Law, second edition, 1969

журмын судалгааны төв (Policy procedure research center)⁷, АНУ-д Хууль сахиулах байгууллагуудын стандартын хороо (Commission on Accreditation in Law Enforcement)⁸, Олон улсын цагдаагийн дарга нарын холбоо (Association of Chiefs of Police)⁹, Үндэсний хууль сахиулах байгууллагын бодлогын төв (National Law Enforcement Policy Center)¹⁰ зэрэг байгууллагууд байдаг. Зарим газарт хувийн байгууллагад захиалга өгч стандарт журмаа боловсруулдаг байна.

Тухайн цагдаагийн байгууллагын чиг үүрэг, хариуцсан нутаг дэвсгэр зэргээс шалтгаалан дотоод журам нь том, бага янз бүр байна. АНУ-д Үндэсний цагдаагийн газар гэж байдаггүй бөгөөд муж, хотын цагдаагийн газар бүрт өөрийн дотоод журам гаргадаг, жишээ нь, Калифорн мужийн Белмонт хотын цагдаагийн газрын дотоод журам гэхэд 500 орчим хуудастай. Энэ хот нь 26 мянган хүн амтай, цагдаагийн газар нь ердөө 100 орчим алба хаагчтай. Гэтэл Нью-Йоркийн цагдаагийн газрын зөвхөн эргүүлийн цагдаагийн стандарт журам нь 1500 гаруй хуудастай байна.

Япон, Өмнөд Солонгос зэрэг улсууд нэгдмэл улс учраас зөвхөн Үндэсний цагдаагийн газраас стандарт журмыг баталж, улсын хэмжээнд нэг стандарт журмыг мөрддөг.

Энэ бүгдээс үзэхэд стандарт тогтоосон, сонгох боломжтой хэм хэмжээ агуулсан, системчлэж кодчилсон стандарт журам нь байгууллагын дотоодод үйлчлэж, үйл ажиллагаагаа оновчтой болгож, үр дүнг дээшлүүлэх, байгууллага, алба хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах боломжийг бүрдүүлдэг байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн баримт бичгийг системчлэн боловсруулах ажлын үр дүн, санал, зөвлөмж:

Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлд 1-т “...үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн” хэмээн заасан бөгөөд төрийн энэхүү үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэгч нэг байгууллага нь цагдаагийн байгууллага болохыг Цагдаагийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор тогтоон хуульчилжээ.

Хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ биелүүлэх явцад цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд тодорхой хүндрэл бэрхшээл учирсаар байгааг нийгмийн бүхий л түвшинд ярьж, бичиж, энэ байдлыг нь төрийн гүйцэтгэх эрх мэдлийн түвшинд зарим талаар хүлээн зөвшөөрч үйл ажиллагааны зохих шинэтгэл хийхийг удирдлагын хийгээд эрдэм шинжилгээ, судалгааны хүрээнд эрэлхийлж байна.

Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх үндсэн эрх, эрх чөлөөг Монгол Улсын Үндсэн хуульд тодорхой зааж, хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна хэмээн хуульчилсан билээ.

Үндсэн хуулиар батлгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, чиг үүргээ хэрэгжүүлэх Цагдаагийн үйл ажиллагаанд тулгарч буй хүндрэл бэрхшээлүүд олон бий. Тэдгээр бэрхшээлийг объектив болон субъектив хүчин зүйл хэмээн ангилж болох бөгөөд хууль сахиулах үйл ажиллагааны үүднээс авч үзвэл объектив нөхцөл байдал нь шийдвэрлэгч үүрэгтэй байна.

Тэгэхдээ цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтыг сайжруулах хэрэгтэй гэсэн эрх зүйн тодорхойгүй шаардлага тавих бүс, харин хууль сахиулах үйл ажиллагаа хэрхэн хуулийн хүрээнд явуулах вэ?

⁷ <https://www.npa.go.jp/>

⁸ www.calea.org/

⁹ www.theiacp.org

¹⁰ www.theiacp.org/Model-Poli...

гэдэгт анхаарах нь зүйтэй болов уу. Өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллага, алба хаагч хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа хэрхэн хууль тогтоомжид нийцүүлэн явуулах вэ гэдэг нь асуудал юм.

Хуульд бүрэн нийцсэн, хүний эрх, эрх чөлөөг дээдлэхэд утга агуулга нь чиглэсэн, цагдаагийн алба хаагч хуулиар олгогдсон албан үүргээ гүйцэтгэхэд “чиг шугам—номлол” нь болох үйл ажиллагааны иж бүрдэл бүхий журамтай байх нь хууль дээдлэн ажиллахын анхны шалгуур нь байх учиртай.

Үүний тулд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг хуульд нийцүүлэн эрх зүйн хийдэлгүй, давхардалгүй иж бүрдэл болгон боловсруулах, тэдгээрийг системчлэн коджуулах ажил тун чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Иж бүрдэл бүхий үйл ажиллагааны журам нь цагдаагийн үйл ажиллагааны арга зүйг хөгжүүлэхийн дээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, үндэсний эрх зүйн мэдээллийн санд тодорхой хувь нэмэр оруулах учиртай.

Мөн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд тулгарч буй хамгийн гол бэрхшээлийн нэг нь хууль тогтоомж, эрх зүйн бусад актаар цагдаагийн байгууллагад хүлээлгэсэн үүргийг хэрхэн, хаана, ямар нөхцөлд, чухам ямар албан тушаалтан, ямар зөвшөөрөл хязгаар, хоригтойгоор гүйцэтгэх, хэрэгжүүлэх процессын хэм хэмжээ дутмаг байгаа явдал юм. Ингэхээр цагдаагийн байгууллага, алба хаагчид хуулиудад заасан үүргээ тодорхой журмын дагуу явуулах нь хууль зүйн шаардлага болж байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчдын эрх хэмжээ, хийж гүйцэтгэх ажлын цар хүрээ, үүрэг хариуцлага нь тэдгээр хууль болон хууль тогтоомжид нийцсэн эрх зүйн актуудаар тодорхойлогдох учиртай. Энэ утгаараа цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчинд бодитой судалгаа шинжилгээ хийж, хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид нийцсэн үйл ажиллагааны журмыг системчлэн бүртгэх, иж бүрдэл болгон боловсруулах, хүчин төгөлдөр мөрдөж ирсэн ажил хөдөлмөрийн үйл ажиллагааг зохицуулж буй журмуудын агуулга чанарыг хуульд нийцүүлэх, практик шалгуурт ойртуулах нь нэгэн цогц үйл ажиллагаа болж байгаа юм.

Цагдаагийн байгууллага, алба хаагчийн ажил хөдөлмөрийн үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгож, системчлэн бүртгэлд оруулах, тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах арга зүйг зүй ёсоор хэвшүүлэх нь тухайн хэм хэмжээний актын эрх зүйн зохицуулалтын хүчин чадал, хэрэглээний ач холбогдлыг дээшлүүлэхийн зэрэгцээ үйл ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг хамгалах, цагдаагийн алба хаагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах гол хүчин зүйл болно.

Даяаршлийн нөлөөн дор цагдаагийн байгууллага Олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, эрх зүйн акт буюу цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг системчлэн кодлох, нэр төрлийг хуулиар үүрэг болгосон зүйл бүрт нийцүүлэх замаар эрх зүйн хийдэл гаргахгүй байх хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллагын хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх үүрэг, ажил, үйлчилгээ өргөжин тэлж нийгмийн олон талт харилцаанд оролцож буй онцлогийг харгалзан гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг баталтгаатай хангах зүй ёсны шаардлага тавигдаж байгаа юм. Түүнчлэн, Монгол Улсын Үндсэн хууль, НҮБ-ын Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон Олон улсын эрх зүйн бусад баримт бичигт тунхаглан заасан хүний эрх, эрх чөлөөг хангахад хууль зүйн нарийвчилсан зохицуулалт онцгой ач холбогдолтой.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам системчлэгдснээр цагдаагийн байгууллага, алба хаагчийн хэрэглэх хууль тогтоомж, эрх зүйн актын нэгдсэн сан бий болж, алба хаагч бүр үйл ажиллагааныхаа эрх зүйн үндэслэлийг нэг дороос шуурхай олж авах, судлах, зөв ойлгон хэрэглэх нөхцөл бүрдэж, цагдаагийн байгууллага, албан хаагчийн хууль хэрэгжүүлэх, хэрэглэх үйл ажиллагаанд цоо шинэ ахиц дэвшил гарч, шинэчлэл явагдана гэж үзэж байна. Мөн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн зөрчилдөөн арилж, цаашид нийгмийн хөгжлийн шаардлагаар цаг тухайд өөрчилж шинэчлэх ажилд зарчмын шинжтэй өөрчлөлт бий болж хууль тогтоох, хэрэгжүүлэх, тайлбарлах үүрэг бүхий бусад байгууллагын үйл ажиллагааг хөнгөвчилж тэдгээр байгууллагатай үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд ач холбогдолтой болно.

Цагдаагийн алба хаагчийн эрх үүрэг, үйл ажиллагааны журам хэдий чинээ тодорхой ойлгомжтой, хуульд нийцсэн байна, төдий чинээгээр цагдаагийн алба хаагчид хүний эрх, эрх чөлөөг хамгаалж чадна. Мөн сайн хууль-эрх зүйн орчин цагдаагийн алба хаагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хамгийн найдвартай арга болох нь дамжиггүй.

Цагдаагийн үйл ажиллагааг зохицуулах хэм хэмжээний стандартыг тогтоосноор цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд тулгарч байсан хүндрэл бэршээлээс хамгийн том объектив хүчин зүйл байхгүй болж үйл ажиллагаанд ахиц дэвшил гарч, цаашид субъектив хүчин зүйлийг арилгах буюу “Үйл ажиллагааны журам”-ыг нэг мөр, хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх боловсрол, мэдлэг, ур чадвар, ухамсар, мэргэжлийн ёс зүйтэй боловсон хүчин, тэдгээрийг бэлтгэн гаргах тогтолцоог бий болгох зохилт тавигдах болно гэж үзэж байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрээд хэрэгжиж буй дээрх туршлагыг хууль сахиулах, төрийн бусад байгууллагад нэвтрүүлэх, улмаар Хууль сахиулахын их сургуулийн сургалтаар түлхүү оруулах, журмын системчлэл, зохицуулалтыг эрдэм шинжилгээ, судалгаатай уялдуулан боловсронгуй болгож байх нь зүйтэй гэсэн санал, зөвлөмжийг дэвшүүлж байна.

Эх сурвалжийн жагсаалт.

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Цагдаагийн албаны тухай хууль
3. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр
4. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын (эмхэтгэл) 1, 2, 3 дугаар хэвлэл
5. Ж.Долгорсүрэн, Д.Булган, Монгол Улсын цагдаагийн эрх зүйн курс, 2014
6. Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүйн удиртгал, 2012
7. Т.Молотов, Орчин үеийн баримт бичиг, ном хэвлэлийн онол, арга зүйн асуудал, 2015
8. Т.Сэнгэдорж, Хууль зүйн шинжлэх ухаан 2015
9. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үүсэл, хөгжил, Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл 2011-07-05
10. П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги 2008 он, 2 дахь хэвлэлт
11. С.Волкер Америкийн цагдаагийн байгууллага Oxford English Dictionary
12. Doreen Martel What are Corporate Bylaws? 2011 <http://www.brighthub.com/office/entrepreneurs/articles/43973.aspx>
13. Lon Luvois Fuller The Morality of Law, second edition, 1969
14. David Grusenmeyer, Developing Effective Standard Operating Procedures, Sr. Extension Associate PRO-DAIRY, Cornell University